



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2002 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Баатар овогтой Батзаяаг 2002-2003 оны хичээлийн жилээс АНУ-ын Соүф Дакотагийн Уул уурхай, технологийн сургуулийн магистрантурт уул уурхайн чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД